



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Налайх дүүргийн Боловсролын хэлтсийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2024/667/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2024 он</p>	<p>Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн дарга Х.Түвшинбаяр Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: С.Гантөгс Утас: 315558 Цахим хаяг: gantugss@audit.gov.mn</p> <p>Аудитор: Б.Одончимэг Утас: 325093 Цахим хаяг: battogoon@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024.02.23 № 275
танай _____-ны № _____-т

НАЛАЙХ ДҮҮРГИЙН
БОЛОВСРОЛЫН
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.ЭНХ-УЧРАЛ
ТАНАА

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Дотоод аудитын албаны 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Налайх дүүргийн боловсролын хэлтсийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн шууд захирагчийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 165,934.6 мянган төгрөгийн залруулаагүй алдаа, зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс хэтэрсэн бөгөөд УСНББОУС болон холбогдох хууль, журамд нийцээгүй, санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх", "Иж бүрэн байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд цалингийн зардлаас шагнал, урамшуулал олгосон, үндсэн хөрөнгө, бараа материалын жилийн эцсийн тооллого хийж, тооцоо бодоогүй, бараа материалыг тус дансаар дамжуулахгүйгээр шууд зарцуулж тайлагнасан зэрэг асуудлууд байна.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 8 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснийг 90.5 хувийн хэрэгжилттэйгээр гүйцэтгэн, тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>12,084,021.49</u>	<u>10,374,817.90</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	11,209,591.90	10,374,817.90
354	Хангамжийн материал	11,209,591.90	10,374,817.90
35410	Бичиг хэргийн материал	2,637,200.00	2,329,936.00
35420	Аж ахуйн материал	3,485,910.00	2,958,400.00
35470	Бусад хангамжийн материал	5,086,481.90	5,086,481.90
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>77,757,828.92</u>	<u>91,285,626.48</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	77,757,828.92	91,285,626.48
392	Биет хөрөнгө	25,957,828.92	39,485,626.48
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	63,648,468.20	83,229,168.20
39206	Хуримтлагдсан элэгдэл	(39,243,469.76)	(45,573,442.08)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	11,798,250.20	12,668,250.20
39208	Хуримтлагдсан элэгдэл	(10,500,719.72)	(11,093,649.84)
39214	Бусад үндсэн хөрөнгө	255,300.00	255,300.00
393	Биет бус хөрөнгө	51,800,000.00	51,800,000.00
39301	Программ хангамж	950,000.00	950,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(950,000.00)	(950,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	51,800,000.00	51,800,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>89,841,850.41</u>	<u>101,660,444.38</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	<u>127,662.18</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	127,662.18
413	Өглөг	-	127,662.18
41310	Ажилчидтай холбогдсон өглөг		127,662.18
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>89,841,850.41</u>	<u>101,532,782.20</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	89,841,850.41	101,532,782.20
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	57,851,746.45	57,851,746.45
51101	Өмч: - төрийн	57,851,746.45	57,851,746.45
512	Хуримтлагдсан үр дүн	31,990,103.96	43,681,035.75
51210	Өмнөх үеийн үр дүн	26,058,423.82	31,990,103.96
51220	Тайлант үеийн үр дүн	5,931,680.14	11,690,931.79
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>89,841,850.41</u>	<u>101,660,444.38</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	166,000,900.00	235,777,541.17
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	52,351,093.17
120	Нийтлэг татварын бус орлого	-	52,351,093.17
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /бараа материал/	-	52,351,093.17
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	166,000,900.00	183,426,448.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	122,247,900.00	177,485,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	122,247,900.00	177,485,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	43,753,000.00	5,940,648.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,440,000.00	5,940,648.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	160,069,219.86	224,086,609.38
21	УРСГАЛ ЗАРДАЛ	160,069,219.86	224,086,609.38
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	137,328,366.51	217,435,112.02
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	72,322,771.66	125,114,178.13
210101	Үндсэн цалин	53,071,473.66	72,996,959.44
210102	Нэмэгдэл	10,091,585.00	29,851,841.17
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,452,000.00	15,527,283.52
210104	Урамшуулал	3,707,713.00	6,738,094.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9,051,988.00	15,553,931.28
210201	Тэтгэврийн даатгал	6,156,243.43	8,994,166.09
210202	Тэтгэмжийн даатгал	724,263.02	1,867,629.86
210203	ҮОМШӨ-ний даатгал	579,410.44	916,539.37
210204	Ажилгүйдлийн даатгал	143,542.79	330,449.32
210205	Эрүүл мэндийн даатгал	1,448,528.32	3,445,146.64
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,996,000.00	5,040,000.00
210304	Байрны түрээс	3,996,000.00	5,040,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,160,645.65	60,600,462.17
210401	Бичиг хэрэг	2,902,100.00	2,178,250.00
210402	Тээвэр, шатахуун	1,148,700.00	4,570,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	519,355.65	527,509.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,150,490.00	973,610.00
210409	Бараа материал шилжүүлсний зардал	-	52,351,093.17
2105	Нормативд зардал	15,275,000.0	-
210503	Нормын хувцас зөөлөн эдлэл	15,275,000.0	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	237,300.00	440,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	237,300.00	440,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	30,284,661.20	10,686,540.44

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,159,300.00	1,901,538.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,864,200.00	1,862,100.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	5,261,161.20	6,922,902.44
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,740,853.35	6,651,497.36
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,456,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,456,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	16,284,853.35	6,651,497.36
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	16,284,853.35	6,651,497.36
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>5,931,680.14</u>	<u>11,690,931.79</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>5,931,680.14</u>	<u>11,690,931.79</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>166,000,900.00</u>	<u>183,426,448.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	166,000,900.00	183,426,448.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	122,247,900.00	177,485,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	122,247,900.00	177,485,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	43,753,000.00	5,940,648.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,440,000.00	5,940,648.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>156,000,900.00</u>	<u>162,975,748.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	156,000,900.00	162,975,748.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	133,060,046.65	156,324,250.64
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	71,809,719.00	124,351,253.48
210101	Үндсэн цалин	53,729,547.00	72,234,034.79
210102	Нэмэгдэл	9,400,459.00	29,851,841.17
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,972,000.00	15,527,283.52
210104	Урамшуулал	3,707,713.00	6,738,094.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,491,072.00	15,314,764.16
210201	Тэтгэврийн даатгал	5,774,820.27	8,994,166.29
210202	Тэтгэмжийн даатгал	679,389.81	1,628,462.54
210203	ҮОМШӨ-ний даатгал	543,511.87	916,539.37
210204	Ажилгүйдлийн даатгал	134,568.15	330,449.32
210205	Эрүүл мэндийн даатгал	1,358,781.90	3,445,146.64
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,996,000.00	5,040,000.00
210304	Байрны түрээс	3,996,000.00	5,040,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,308,955.65	6,549,595.00
210401	Бичиг хэрэг	1,362,100.00	1,223,086.00
210402	Тээвэр, шатахуун	498,700.00	4,570,000.00

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	519,355.65	527,509.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,488,800.00	229,000.00
2105	Нормативд зардал	18,000,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	18,000,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	402,300.00	440,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	402,300.00	440,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	26,052,000.00	4,628,638.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,830,000.00	2,266,538.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,222,000.00	2,362,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,940,853.35	6,651,497.36
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,656,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	16,284,853.35	6,651,497.36
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	16,284,853.35	6,651,497.36
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>10,000,000.00</u>	<u>20,450,700.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	10,000,000.00	20,450,700.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	10,000,000.00	20,450,700.00
2200	Дотоод эх үүсвэрээр	10,000,000.00	20,450,700.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	10,000,000.00	20,450,700.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(10,000,000.00)</u>	<u>(20,450,700.00)</u>

2.4 Аудит хийсэн ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2022 оны 1-р сарын 31-ны үлдэгдэл	57,851,746.45	26,058,423.82	83,910,170.27
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	57,851,746.45	26,058,423.82	83,910,170.27
C07	Тайлант үеийн үр дүн		5,931,680.14	5,931,680.14
C08	2022 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	57,851,746.45	31,990,103.96	89,841,850.41
D01	2023 оны 1-р сарын 1-ны үлдэгдэл	57,851,746.45	31,990,103.96	89,841,850.41
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	57,851,746.45	31,990,103.96	89,841,850.41
D08	Тайлант үеийн үр дүн		11,690,931.79	11,690,931.79
D09	2023 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	57,851,746.45	43,681,035.75	101,532,782.20

2.5 Аудит хийсэн ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	177,485,800.00	170,834,302.64	(6,651,497.36)	96.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	177,485,800.00	170,834,302.64	(6,651,497.36)	96.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	177,164,300.00	170,834,302.64	(6,329,997.36)	96.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	124,686,000.00	124,351,253.48	(334,746.52)	99.7
210101	Үндсэн цалин	65,919,600.00	72,234,034.79	6,314,434.79	109.6
210102	Нэмэгдэл	38,444,200.00	29,851,841.17	(8,592,358.83)	77.6
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,260,000.00	15,527,283.52	8,267,283.52	213.9
210104	Урамшуулал	13,062,200.00	6,738,094.00	(6,324,106.00)	51.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20,109,400.00	15,314,764.16	(4,794,635.84)	76.2
210201	Тэтгэврийн даатгал	15,348,500.00	8,994,166.29	(6,354,333.71)	58.6
210202	Тэтгэмжийн даатгал	1,190,200.00	1,628,462.54	438,262.54	136.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	952,200.00	916,539.37	(35,660.63)	96.3
210204	Ажилгүйдлийн даатгал	238,000.00	330,449.32	92,449.32	138.8
210205	Эрүүл мэндийн даатгал	2,380,500.00	3,445,146.64	1,064,646.64	144.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,040,000.00	5,040,000.00	-	100.0
210304	Байрны түрээс	5,040,000.00	5,040,000.00	-	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	3,057,900.00	2,730,295.00	(327,605.00)	89.3
210401	Бичиг хэрэг	1,223,500.00	1,223,086.00	(414.00)	100.0
210402	Тээвэр, шатахуун	244,400.00	300,000.00	55,600.00	122.7
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	576,000.00	527,509.00	(48,491.00)	91.6
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	284,300.00	-	(284,300.00)	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	729,700.00	679,700.00	(50,000.00)	93.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,000,000.00	20,000,000.00	-	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	20,000,000.00	20,000,000.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,008,000.00	440,000.00	(568,000.00)	43.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,008,000.00	440,000.00	(568,000.00)	43.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,263,000.00	2,957,990.00	(305,010.00)	90.7
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	900,900.00	595,890.00	(305,010.00)	66.1
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,362,100.00	2,362,100.00	-	100.0
213	Урсгал шилжүүлэг	321,500.00	-	(321,500.00)	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	321,500.00	-	(321,500.00)	
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	177,485,800.00	170,834,302.64	(6,651,497.36)	96.3
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	177,485,800.00	170,834,302.64	(6,651,497.36)	96.3
131001	Улсын төсвөөс санхүүжих	177,485,800.00	170,834,302.64	(6,651,497.36)	96.3
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	6.00		-	100.0

620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	5.00	5.00	-	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	6.00	6.00	-	100.0
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	5.00	5.00	-	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	1.00	1.00	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,940,648.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,940,648.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,940,648.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,270,000.00
210402	Тээвэр, шатахуун	4,270,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,670,648.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,670,648.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,940,648.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,940,648.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,940,648.00

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 625,924.7 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулж, нийт аудитаар 1,200.0 мянган төгрөгийн зөрчил²-д төлбөрийн акт, 159,277.5 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 5,457.1 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөн.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
НД-ын Боловсролын хэлтэс	4	625,924.7			4	625,924.7	4	625,924.7				
Дүн	4	625,924.7			4	625,924.7	4	625,924.7				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллага Д шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Нийслэлийн боловсролын газар	4	165,934.6	1	1,200.0	1	159,277.5	2	5,457.1				
Дүн	4	165,934.6	1	1,200.0	1	159,277.5	2	5,457.1				

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
	НИЙТ	1	1				1		